

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шvvхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газар
БТСХ	Биеийн Тамир Спортын Хороо
УАГ	Үндэсний Аудитын Газар
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
СҮЛД БИЕИЙН ТАМИР СПОРТ
ХОРООНЫ ДАРГА Н.БАТСУУРЬ
ТАНАА

2020.02.20 № 06/547
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын Сүлд Биеийн Тамир Спорт Хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын Сүлд Биеийн Тамир Спорт Хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын Сүлд Биеийн Тамир Спорт Хорооны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хорооны дарга Н.Батсуурь Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шаардлагатай үйл ажиллагааны зардлуудыг төсөвт тусгуулж батлагдсан ангиллын дагуу зарцуулан ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлог, холбогдох стандарт, хууль, дүрэмтэй нийцүүлэн боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ЯАГ-тай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн “Мэдээлэл-Аудит” ХХК аудит хийлээ.

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитор Д.Туяа, шинжээч Ц.Отгонжаргал, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

ШШГЕГ-ын алба хаагчдын эрүүл чийрэг, бие бялдрын бэлтгэлжилтийн норматив үзүүлэлтийг дээшлүүлэх, олон нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох, спортоор хичээллэх таатай орчинг бүрдүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэж улс, тив, дэлхий, олимпын аваргуудыг төрүүлэхэд Сүлд БТСХорооны эрхэм зорилго оршино.

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир спортын үйл ажиллагаа явуулах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хорооны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомж, байгууллагын онцлогтой нийцээгүй байна.

ШШГЕГ-ын Сүлд БТСХороо нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “UNICUS” программ хангамж ашигладаг байна.

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитын 3 чиглэлд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 117,060.5 мянган төгрөгөөс тооцон 1,170.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг хэвээр авч 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 226,137.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож материаллаг байдлын түвшинг 2,261.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,196.1 мянган төгрөгөөр буюу 4,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	16,580.4	17,551.2	970.8
Үндсэн хөрөнгө	366,715.4	347,548.5	(19,166.9)
Нийт хөрөнгө	383,295.8	365,099.7	(18,196.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	383,295.8	365,099.7	(18,196.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	383,295.8	365,099.7	(18,196.1)

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал буюу тамирчдын бэлтгэлийн спортын хэрэглэл худалдан авсан нь шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материал буюу тамирчдын бэлтгэлийн хувцас, спортын хэрэглэл зэрэг бага үнэтэй түргэн элэгдэх бараа материал байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны хөрөнгийн элэгдлийн зардал 23,881.9 мянган төгрөгөөр буурч, ШШГЕГазраас үнэ төлбөргүй хүлээн авсан 4,475.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 365,099.7 мянган төгрөг болж 18,196.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн буурсантай холбоотой.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 2,127.5 мянган төгрөгийн бичилт нь 2018 онд Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэн "Спорт зал, үүдний хэсгийн хамт" 355,719.0 мянган төгрөгөөс 353,591.5 мянган төгрөг болж, хөрөнгийн үнэ цэнэ буурсныг санхүүгийн тайланд "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансанд сөрөг утгатай тайлагнасан байсныг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх урсгал үйл ажиллагааны зардалд зориулан 202,213.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт зардлын 191,643.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,570.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 100 хувь биелсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 200,933.2 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлаа 1,279.8 мянган төгрөг буюу 0,6 хувиар хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: ШШГЕГазраас үнэ төлбөргүй 5,728.9 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан. Үүнээс 4,475.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,200.0 мянган төгрөгийн шатахуун, 53.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал хүлээн авсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж 1 эрсдэл тодорхойлж, нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,514.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,127.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,387.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх аудитын зөвлөмж өглөө. Үүнд:

- Аудитаар 2018 онд Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэн "Спорт зал, үүдний хэсгийн хамт" 355,719.0 мянган төгрөгөөс 353,591.5 мянган төгрөг болж хөрөнгийн үнэ цэнэ 2,127.5 мянган төгрөгөөр буурсныг санхүүгийн тайланд "Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансанд сөрөг утгатай тайлагнасан байсныг залруулсан;
- Аудитаар илэрсэн 2,387.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд аудитын зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа;

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй аудитын түүвэрт хамрагдсан.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй дүгнэлт”

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 2,387.4 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралт № 1 "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-д "Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгэн харьяа төрийн санд хүргүүлнэ", 5.5-д "Төсвийн байгууллага журмын 5.1-д заасан бусад төсвийн зохицуулалт хийх саналыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчигдөх, үргүй зардал гаргах;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана;

3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

2015 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг одоо мөрдөж буй нь байгууллагын онцлогийг тусгаагүй, холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангахгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-д Ерөнхий нягтлан

бодогчийн эрх, үүрэг нь "... байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

НББББ, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Яамнаас гаргасан холбогдох журам, зааварт нийцэхгүй байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын онцлог, холбогдох стандарт, хууль журмыг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,580,429.47</u>	<u>17,551,207.91</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	16,580,429.47	17,551,207.91
351	Түүхий эд материал	12,412,600.00	14,527,148.00
35110	Тусгай зориулалттай материал	12,412,600.00	14,527,148.00
354	Хангамжийн материал	4,167,829.47	3,024,059.91
35410	Бичиг хэргийн материал	826,594.10	317,871.43
35420	Аж ахуйн материал	1,252,350.00	1,285,250.00
35440	Түлш, шатах тослох материал	60,000.00	-
35450	Барилгын засварын материал	326,680.00	90,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,702,205.37	1,330,938.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>366,715,422.97</u>	<u>347,548,547.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,715,422.97	347,548,547.61
392	Биет хөрөнгө	362,885,170.75	343,985,651.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	353,591,500.00	353,591,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(19,643,972.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,461,286.00	11,461,286.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,482,895.38)	(6,931,186.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,039,823.82	10,754,823.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,724,543.69)	(5,246,800.33)
393	Биет бус хөрөнгө	3,830,252.22	3,562,896.42
39301	Програм хангамж	4,277,692.17	4,277,692.17
39302	Хуримтлагдсан элэгдэл	(447,439.95)	(714,795.75)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>383,295,852.44</u>	<u>365,099,755.52</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>383,295,852.44</u>	<u>365,099,755.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	383,295,852.44	365,099,755.52
512	Хуримтлагдсан үр дүн	383,295,852.44	365,099,755.52
51210	Өмнөх үеийн үр дүн	385,423,376.96	383,295,852.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	(18,196,096.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(2,127,524.52)	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>383,295,852.44</u>	<u>365,099,755.52</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	227,069,286.00	207,941,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,733,100.00	16,298,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,672,000.00	10,570,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,061,100.00	5,728,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,336,186.00	191,643,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,651,900.00	191,643,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,651,900.00	191,643,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,332,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,332,000.00	
1330	Төсвийн захирагчдаас	2,352,286.00	-
133003	Хөрөнгийн	2,352,286.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	251,385,130.97	226,137,996.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,385,130.97	226,137,996.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,433,130.97	224,558,162.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,382,700.00	170,530,400.00
210101	Үндсэн цалин	97,359,500.00	113,662,500.00
210102	Нэмэгдэл	48,418,200.00	54,019,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	605,000.00	1,848,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,636,500.00	4,237,965.53
210201	Тэтгэврийн даатгал	638,991.55	
210205	Эрүүл мэндийн даатгал	2,997,508.45	4,237,965.53
2104	Хангамж, бараа материалын зардал	9,218,602.22	5,535,889.56
210401	Бичиг хэрэг	1,234,455.90	702,622.67
210402	Тээвэр, шатахуун	5,152,000.00	2,432,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	230,400.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,501,746.32	2,401,266.89
2105	Нормативт зардал	2,941,100.00	-
210502	Хоол, хүнс	2,941,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,988,970.00	3,876,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	927,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	120,000.00	212,800.00
210604	Урсгал засвар	14,868,970.00	2,736,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,702,000.00	810,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,225,000.00	540,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	477,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,563,258.75	39,567,427.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,613,101.40	15,685,552.00

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	332,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,618,157.35	23,881,875.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	952,000.00	1,579,834.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	783,800.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	783,800.00	300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,200.00	1,279,834.7
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,200.00	1,279,834.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(24,315,844.97)</u>	<u>(18,196,096.92)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(24,315,844.97)</u>	<u>(18,196,096.92)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	221,655,900.00	202,213,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,672,000.00	10,570,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,672,000.00	10,570,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,672,000.00	10,570,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	200,983,900.00	191,643,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,651,900.00	191,643,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,651,900.00	191,643,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,332,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,332,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	220,855,900.00	201,973,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,855,900.00	201,973,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,903,900.00	200,393,165.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,382,700.00	170,530,400.00
210101	Үндсэн цалин	97,359,500.00	113,662,500.00
210102	Нэмэгдэл	48,418,200.00	54,019,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	605,000.00	1,848,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,636,500.00	4,237,965.53
210201	Тэтгэврийн даатгал	638,991.55	-
210205	Эрүүл мэндийн даатгал	2,997,508.45	4,237,965.53
2104	Хангамж, бараа материалын зардал	8,540,200.00	3,342,000.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	140,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	1,172,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	260,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,680,000.00	2,030,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,405,500.00	3,742,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,030,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	532,000.00	212,800.00
210604	Урсгал засвар	14,873,500.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,077,000.00	950,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,000.00	540,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	477,000.00	410,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,862,000.00	17,590,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,530,000.00	17,590,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	332,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	952,000.00	1,579,834.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	783,800.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	783,800.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,279,834.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,279,834.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	168,200.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	168,200.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>800,000.00</u>	<u>240,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	800,000.00	240,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	800,000.00	240,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	800,000.00	240,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(800,000.00)</u>	<u>(240,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	409,739,221.93		409,739,221.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	409,739,221.93	0.00	409,739,221.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	(2,127,524.52)	0.00		(2,127,524.52)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			(24,315,844.97)		(24,315,844.97)
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	(2,127,524.52)	385,423,376.96	0.00	383,295,852.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(2,127,524.52)		(2,127,524.52)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00		383,295,852.44	0.00	383,295,852.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00		0.00
D08	Тайлант үеийн үр дүн			(18,196,096.92)		(18,196,096.92)
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00		365,099,755.52	0.00	365,099,755.52

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	202,213,000.00	200,933,165.53	1,279,834.47	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,213,000.00	200,933,165.53	1,279,834.47	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,913,000.00	200,633,165.53	1,279,834.47	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,530,400.00	170,530,400.00		100
210101	Үндсэн цалин	113,662,500.00	113,662,500.00		100
210102	Нэмэгдэл	54,019,900.00	54,019,900.00		100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,848,000.00	1,848,000.00		100
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,517,800.00	4,237,965.53	1,279,834.47	76.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,517,800.00	4,237,965.53	1,279,834.47	76.8
2104	Хангамж, бараа материалын зардал	3,342,000.00	3,342,000.00		100
210401	Бичиг хэрэг	140,000.00	140,000.00		100
210402	Тээвэр, шатахуун	1,172,000.00	1,172,000.00		100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,030,000.00	2,030,000.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,982,800.00	3,982,800.00		100
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,270,000.00	1,270,000.00		100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	212,800.00	212,800.00		100
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	950,000.00	950,000.00		100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000.00	540,000.00	410,000.00	56.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	410,000.00	(410,000.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,590,000.00	17,590,000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,590,000.00	17,590,000.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00		100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	202,213,000.00	200,933,165.53	1,279,834.47	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	191,643,000.00	190,363,165.53	1,279,834.47	99.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	191,643,000.00	190,363,165.53	1,279,834.47	99.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,570,000.00	10,570,000.00		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,570,000.00	10,570,000.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	1	1		
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020.02.18

Аудитын нэр:

ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2020/220/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

ШШГЕГ-ын Сүлд БТСХороо

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2,387.4 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	2,387.4	Зөвлөмж өгөх	ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны Дарга, нягтлан бодогч	Н.Батсуурь С.Амар-Амгалан
2	2015 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг одоо мөрдөж буй нь байгууллагын онцлогийг тусгаагүй, холбогдох стандартын шаардлага хангахгүй байна		Зөвлөмж өгөх	ШШГЕГ-ын Сүлд БТСХорооны Дарга, нягтлан бодогч	Н.Батсуурь С.Амар-Амгалан
	Дүн	2,387.4			

